

МОНГОЛ УЛС  
САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ  
ТОГТООЛ

2011 оны 11 сарын 02 өдөр

Дугаар 302

Улаанбаатар хот

“Жолоочийн хариуцлагын албан журмын даатгалын  
үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл олгох журам” батлах тухай

Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 6.1.2 дахь заалтыг үндэслэн Санхүүгийн зохицуулах хорооноос ТОГТООХ нь:

- 1.“Жолоочийн хариуцлагын албан журмын даатгалын үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл олгох журам”-ыг хавсралтаар баталсугай.
2. Энэ журмыг “Төрийн мэдээлэл” эмхэтгэлд Жолоочийн даатгалын тухай хууль хэвлэгдэн гарсан өдрөөс эхлэн дагаж мөрдсүгэй.
3. Жолоочийн даатгалын тухай хуульд заасан, уг хууль мөрдөгдөж эхлэх хүртэлх хугацаанд жолоочийн хариуцлагын албан журмын даатгалын үйл ажиллагаа эрхлэхгүй байхыг даатгагч нарт анхааруулсугай.
4. Батлагдсан журмын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Даатгалын газар /С.Ганболд/-т, олон нийтэд мэдээлэхийг Тамгын газарт тус тус даалгасугай.

ДАРГА

Д.БАЯРСАЙХАН

Санхүүгийн зохицуулах хорооны  
2011 оны 11 дүгээр сарын 02-ны өдрийн  
302 дугаар тогтоолын хавсралт

**ЖОЛООЧИЙН ХАРИУЦЛАГЫН АЛБАН ЖУРМЫН ДААТГАЛЫН  
ҮЙЛ АЖИЛЛАГАА ЭРХЛЭХ ЗӨВШӨӨРӨЛ  
ОЛГОХ ЖУРАМ**

**НЭГ. Нийтлэг үндэслэл**

1.1. Энэхүү журмын зорилго нь Санхүүгийн зохицуулах хороо /цаашид “Хороо” гэх-/ ноос ердийн даатгалын үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөлтэй компани /цаашид “даатгагч” гэх/-д жолоочийн хариуцлагын албан журмын даатгал /цаашид “жолоочийн даатгал” гэх/-ын үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл олгох, зөвшөөрлийн нөхцөл, шаардлагын биелэлтэд хяналт тавих, зөвшөөрлийг хүчингүй болгохтой холбогдсон харилцааг зохицуулахад оршино.

**ХОЁР. Жолоочийн даатгалын үйл ажиллагаа эрхлэх  
зөвшөөрөл олгоход тавигдах шаардлага**

2.1. Нэгээс доошгүй жилийн хугацаанд ердийн даатгалын үйл ажиллагаа эрхэлж, олон нийтэд танигдсан туршлагатай байх;

2.2. Зөвшөөрөл олгохыг хүссэн тухайн нутаг дэвсгэрт Хорооны 2008 оны 61 дүгээр тогтоолоор батлагдсан “Ердийн даатгал, давхар даатгалын болон даатгалын мэргэжлийн оролцгчийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийн журам”-ын 3.8, 3.10-д заасны дагуу зөвшөөрөл авсан салбартай байх;

2.3. Хорооны 2009 оны 211 дүгээр тогтоолоор батлагдсан “Ердийн даатгагчийн төлбөрийн чадварыг тооцох журам”-ын дагуу төлбөрийн чадварын шалгуур үзүүлэлтийг сүүлийн 2 улирал дараалан хангасан байх;

2.4. Жолоочийн даатгалын үйл ажиллагаанд ашиглах программ хангамж, мэдээллийн сангийн бүртгэл хөтлөх боловсон хүчинтэй байх;

2.5. Жолоочийн даатгалын тохиолдлыг шалгаж, шийдвэрлэх шуурхай албатай байх;

2.6. Даатгалын актуарчтай байх;

2.7. Хорооноос шаардлагатай гэж үзсэн бусад нөхцөл, шаардлага.

**ГУРАВ. Жолоочийн даатгалын үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл олгохыг хүссэн  
даатгагчаас бүрдүүлэх баримт бичгийн жагсаалт**

3.1. Жолоочийн даатгалын үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл хүссэн этгээд нь дараах баримт бичгийг бүрдүүлж Хороонд ируулнэ.

3.1.1. Жолоочийн даатгалын үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл олгохыг хүссэн өргөдлийг энэхүү журмын 1 дүгээр хавсралтын дагуу гаргах;

3.1.2. Жолоочийн даатгалын үйл ажиллагаа эрхлэх тухай хувь нийлүүлэгчдийн хурлын шийдвэрийн эх хувь эсхүл нотариатаар гэрчлүүлсэн хуулбар;

3.1.3. Хорооны 2008 оны 61 дүгээр тогтоолоор батлагдсан “Ердийн даатгал, давхар даатгалын болон даатгалын мэргэжлийн оролцогчийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийн журам”-ын 3 дугаар хавсралтын дагуу бүрдүүлсэн жолоочийн даатгалын үйл ажиллагааны мэдээллийн сангийн бүртгэл хөтлөх боловсон хүчин болон даатгалын актуарчийн тодорхойлолт;

3.1.4. Жолоочийн даатгалын үйл ажиллагаа эрхлэхтэй холбогдуулан даатгагчийн бизнес төлөвлөгөөнд оруулсан өөрчлөлт;

3.1.5. Жолоочийн даатгалын үйл ажиллагаанд ашиглах программ хангамжийн тухай танилцуулга;

3.1.6. Жолоочийн даатгалын тохиолдлыг шалгаж, шийдвэрлэх шуурхай албаны бүтэц бүрэлдэхүүн, шуурхай албаны зохион байгуулалтын талаарх танилцуулга;

3.1.7. Шаардлагатай бусад материал.

### **ДОРӨВ. Жолоочийн даатгалын үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл олгох, олгохоос татгалзах**

4.1. Жолоочийн даатгалын үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл олгохыг хүсч даатгагчаас ирүүлсэн баримт бичгийг холбогдох хууль тогтоомж болон энэ журмын дагуу хянаж, шаардлагатай асуудлыг газар дээр нь шалгасны үндсэн дээр тухайн даатгагчийн санхүүгийн чадварт сөргөөр нөлөөлөхгүй, нийтийн болон даатгуулагчийн ашиг сонирхолд хохирол учруулахгүй гэж үзвэл Хороо жолоочийн даатгалын үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрлийг олгоно.

4.2.Хороо зөвшөөрөл олгох, эсэх асуудлыг хуанлийн 30 хоногийн дотор шийдвэрлэнэ. Зөвшөөрөл хүссэн баримт бичгийг үнэн зөв, бүрэн гүйцэд бүрдүүлж эцсийн байдлаар Хороонд ирүүлсэн өдрөөс эхлэн шийдвэрлэх хугацааг тооцно.

4.3.Хорооны тогтоолыг үндэслэн ердийн даатгалын тусгай зөвшөөрлийн гэрчилгээний хавсралтад жолоочийн даатгалын үйл ажиллагаа эрхлэх нутаг дэвсгэрийг заасан тэмдэглэгээг хийж баталгаажуулна.

4.4. Хороо нь дараах үндэслэлээр жолоочийн даатгалын үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл олгохоос татгалзаж, энэ талаарх үндэслэл бүхий тайлбарыг даатгагчид албан бичгээр хүргүүлнэ.

4.4.1. Энэ журмын 2-т заасан шаардлагыг хангаагүй;

4.4.2. Хуурамч баримт бичиг бүрдүүлсэн нь тогтоогдсон;

4.4.3. Бусад хууль тогтоомжид заасан шаардлагыг хангаагүй.

4.5. Хороо дараах үндэслэлээр жолоочийн даатгалын үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрлийг хүчингүй болгож, ердийн даатгалын үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийн гэрчилгээнд ажлын 10 хоногийн дотор энэ тухай тэмдэглэгээг хийнэ:

4.5.1. Даатгагч хүсэлт гаргасан;

4.5.2. Даатгагч татан буугдсан;

4.5.3. Зөвшөөрөл авахдаа хуурамч баримт бичиг бүрдүүлсэн нь тогтоогдсон;

4.5.4. Хорооны 2009 оны 211 дүгээр тогтоолоор батлагдсан “Ердийн даатгагчийн төлбөрийн чадварыг тооцох журам”-ын дагуу төлбөрийн чадварын шалгуур үзүүлэлтийг сүүлийн 2 улирал дараалан хангаагүй;

4.5.5. Зөвшөөрлийн нөхцөл, шаардлагыг удаа дараа буюу ноцтой зөрчсөн.

4.6. Хороо зөвшөөрөл олгосон болон хүчингүй болгосон тухайгаа олон нийтэд хэвлэл мэдээллийн хэрэгслээр шуурхай мэдээлэх бөгөөд хүчингүй болгосон талаар даатгагчид яаралтай мэдэгдэж жолоочийн даатгалын үйл ажиллагаа эрхлэхгүй байхыг бичгээр мэдэгдэнэ.

#### **Тав. Хориглох зүйл**

5.1. Жолоочийн даатгалын үйл ажиллагаа эрхлэхтэй холбогдуулан даатгагч дараах үйл ажиллагаа явуулахыг хориглоно:

5.1.1. Энэхүү журмын 4.1-д заасан зөвшөөрлийг авсан даатгагч Хорооноос даатгалын салбар байгуулах зөвшөөрөл аваагүй нутаг дэвсгэрт жолоочийн даатгалын үйл ажиллагаа эрхлэх;

5.1.2. Жолоочийн даатгалын үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл аваагүй даатгагч Хорооны 2009 оны 16 дугаар тогтоолоор батлагдсан “Сайн дурын даатгалын хэлбэр”-ийн 1.9-д заасан даатгалын үйл ажиллагаа эрхлэх;

5.1.3. Холбогдох бусад хууль тогтоомжоор хориглосон үйл ажиллагаа.

#### **Зургаа. Хяналт, хариуцлага**

6.1. Хороо нь энэ журмын биелэлтэд хяналт тавих бөгөөд журмыг зөрчсөн этгээдэд Жолоочийн даатгалын тухай хууль болон холбогдох бусад хууль тогтоомжид заасны дагуу хариуцлага хүлээлгэнэ.

“Жолоочийн хариуцлагын албан журмын даатгалын үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл олгох журам”-ын 1 дүгээр хавсралт

**ЖОЛООЧИЙН ХАРИУЦЛАГЫН АЛБАН ЖУРМЫН ДААТГАЛЫН  
ҮЙЛ АЖИЛЛАГАА ЭРХЛЭХ ЗӨВШӨӨРӨЛ ХҮССЭН ӨРГӨДӨЛ**

Огноо:.....

Хаана:САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРОО-нд

Засгийн газрын 4-р байр, Бага тойруу-3, Улаанбаатар-46, Монгол улс

Хаанаас:.....

(Өргөдөл гаргагчийн овог нэр, хаяг, утас, факс, электрон шуудангийн хаяг)

Жолоочийн хариуцлагын албан журмын даатгалын үйл ажиллагаа эрхлэх этгээдийн нэр

Хуулийн этгээдийн хувь нийлүүлэгч болон төлөөлөн удирдах зөвлөлийн хурлын шийдвэрийн дугаар:.....

Өргөдөл гаргагч ердийн даатгалын компанийн дүрмийн сангийн бүтцийн талаарх мэдээлэл:

№	Хувь нийлүүлэгчийн овог, нэрс	Эзэмших хувьцаа		Дүрмийн санд эзлэх хувь
		үнэ /мян.төг	тоо ширхэг	
1.				
	Нийт			

Даатгалын тухай хууль, Жолоочийн даатгалын тухай хууль, Санхүүгийн зохицуулах хорооноос баталсан “Жолоочийн хариуцлагын албан журмын даатгалын үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл олгох журам”-д нийцүүлэн жолоочийн хариуцлагын албан журмын даатгалын үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл авахад шаардагдах баримт бичгийг үнэн зөв бүрдүүлж хүргүүлэв. Энэхүү холбогдох баримт бичгийг хуурамчаар бүрдүүлсэн, худал ташаа зүйл орсон бол хариуцлагыг манай компани хүлээх болно.

Өргөдлийг хянан үзэж, жолоочийн хариуцлагын албан журмын даатгалын үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл олгоно уу.

Хуулийн хүрээнд үйл ажиллагаа явуулж, Санхүүгийн зохицуулах хорооноос өгсөн үүрэг, даалгаврыг цаг тухайд нь биелүүлж ажиллах болно.

**ӨРГӨДӨЛ ГАРГАГЧ:**

.....  
(удирдлагын гарын үсэг)  
(тамга тэмдэг)

.....  
(албан тушаал)  
(хуулийн этгээдийн нэр).....